



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/03

Жавхлант

Олон нийтийн эргүүл ажиллуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 зүйлийн 66.1, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.9, 27 дугаар зүйлийн 27.1.2, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн байгууллага болон аж ахуйн нэгжийн олон нийтийн эргүүлд гаргах хуваарийг хавсралт 1-ээр, ажиллах чиг үүргийг хавсралт 2-оор баталсугай.

2. Олон нийтийн эргүүлд аж ахуй нэгж, байгууллагууд 1-2 албан хаагчийг томилж, 10л шатахуунаар хангаж ажиллахыг байгууллага, аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

3. Олон нийтийн эргүүлийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг сумын Хэсгийн төлөөлөгч (Г.Ганбаяр), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Шаравгаваа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР